



Архангай аймаг  
100 жил

# АРХАНГАЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН



2024 ОН



### Аудит хийх үндэслэл, бүрэн эрх, аудитын зорилт:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.4 дэх заалтын дагуу аймгийн 2023 оны төсвийн гүйцэтгэлд аудит хийв.

Архангай аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг шалгаж, дүгнэлт, зөвлөмж гарган аймгийн ИТХ болон төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

1. Орон нутгийн 2023 оны төсвийн орлогыг бодитой төлөвлөж, бүрэн төвлөрүүлсэн эсэх
2. Орон нутгийн 2023 оны төсвийн зарлагыг үндэслэлтэй төлөвлөж, зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулсан эсэх
3. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээ төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх
4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан эсэх
5. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх

### Үндсэн мэдээлэл:



Сангийн Яамнаас орон нутгийн 2023 оны төсвийн суурь орлогыг 14,823.1 сая төгрөгөөр, суурь зарлагыг 32,329.0 сая төгрөгөөр хянасан. Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар Архангай аймагт олгох санхүүгийн дэмжлэгийг 17,505.9 сая төгрөгөөр, улсын төсвөөс орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 8,580.8 сая төгрөгийг баталж байсан бол 2023 оны 6 дугаар сард төрийн албан хаагчийн үндсэн цалинг нэмэгдүүлэхтэй холбогдуулан Сангийн Яамнаас аймгийн суурь зарлагыг 37,684.4 сая төгрөгөөр, суурь орлогыг 16,586.7 сая төгрөгөөр хянаж, 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн “Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулиар Архангай аймагт олгох санхүүгийн дэмжлэгийг 21,098.6 сая төгрөгөөр, улсын төсвөөс орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 10,740.4 сая төгрөгөөр баталжээ.

Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөг Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймаг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлтэй уялдуулан боловсруулан хэрэгжүүлж ажилласан байна. Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг 166 арга хэмжээний хүрээнд 90.9 хувьтай дүгнэсэн ба аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 06 дугаар тогтоолоор “Хангалттай” гэж дүгнэсэн байна.

Орон нутгийн орлого нийт 19,860.3 сая төгрөгийн орон нутгийн төсвийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 21,736.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн, төлөвлөгөөг 109.4 хувиар буюу 1,876.4 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Тайлант онд төлөвлөсөн 26 нэр төрлийн орлогоос 18 нэр төрлийн орлогыг 4,515.3 сая төгрөгөөр давуулан биелүүлж, 8 нэр төрлийн орлогын төлөвлөгөөг 2,634.8 сая төгрөгөөр тасалсан байна.

Аймгийн 2023 оны төсвийн нийт зарлагыг 64,892.5 сая төгрөгөөр төлөвлөснөөс 55,072.7 сая төгрөгийг зарцуулж, зардлын гүйцэтгэл 84.9 хувьтай байна. Харин Аймгийн ТЕЗ-ийн нэмэлт санхүүжилтийн дансаар 2023 онд нийт 1,176.5 сая төгрөг зарцуулагджээ.



Улсын төсвөөс авах ОНХС-ийн орлогын шилжүүлгээр 10,571.4 сая төгрөгийг, улсын төсвөөс 21,098.6 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг тус тус хүлээн авч зарцуулсан байна. Аймгийн ИТХ-ын 2023 оны 6 дугаар сарын 27-ний өдрийн “Аймгийн 2023 оны тодотгосон төсөв батлах тухай” 17 дугаар тогтоолын дагуу Эрдэнэбулган сумаас аймгийн төсөвт 673.5 сая төгрөг төвлөрч, төсөвт байгууллагуудын урсгал санхүүжилтэд зарцуулсан байна.

**Аудитын дүн:**

- ✓ **Орон нутгийн төсвийн орлого 8 нэр төрлөөр 2,634.8 сая төгрөгөөр дутуу төвлөрсний 71.3 хувь буюу 1,877.9 сая төгрөг нь Засгийн газрын дамжуулан зээлийн хүүгийн орлого байна**

Тайлангийн жилд орон нутгийн орлогод 2 удаагийн тодотгол хийгдэж, аймгийн төсвийн орлогыг 18,613.0 мянган төгрөгөөр тодотгон, сумд орон нутгийнхаа онцлог байдалтай уялдуулан хуулиар эрх олгогдсон эрх хэмжээний хүрээнд 8 нэр төрлийн орлогыг 1,247.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж, аймгийн нийт орлого төсвийн төлөвлөлтийн фискал /fiscal/ программд 19,860.3 сая төгрөгөөр төгрөгөөр төлөвлөгдсөн байна.


Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

сая төгрөгөөр

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	ТАТВАРЫН ОРЛОГО	16,274.1	18,778.9	2,504.8	115.4
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,536.2	2,841.4	(694.8)	80.4
3	ХӨРӨНГИЙН ОРЛОГО	50.0	116.4	66.4	232.8
	<b>НИЙТ</b>	<b>19,860.3</b>	<b>21,736.7</b>	<b>1,876.4</b>	<b>109.4</b>

Орон нутгийн төсвийн орлого гүйцэтгэлээр **21,736.7** сая төгрөг төвлөрч, төлөвлөгөө 109.4 хувиар буюу 1,876.4 сая төгрөгөөр давж биелсэн байна. 2023 оны төсвийн орлогын төлөвлөлт 2021 оноос 8,416.0 сая төгрөг, 2022 оноос 4,124.6 сая төгрөгөөр, харин орлогын гүйцэтгэл 2021 оноос 6,546.8 сая төгрөгөөр, 2022 оноос 3,475.8 сая төгрөгөөр өсжээ.

**Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл сүүлийн 3 жилээр**



Татварын 14, татварын бус 3, хөрөнгийн 1, нийт 18 нэр төрлийн орлого 0.4 - 1,856.3 сая төгрөгөөр буюу нийт **2,515.3** сая төгрөгөөр давж биелсэн бөгөөд өндөр дүнгээр давж биелсэн татварын болон татварын бус орлогыг тодруулбал:



- ✓ **Цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын татвар** 1,856.3 сая төгрөгөөр давж биелсэн нь төрийн албан хаагчдын үндсэн цалинг Засгийн газрын 241 дүгээр тогтоолоор нэмсэн, мөн тайлант жилд шинээр байгуулагдан үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын татвар төлөлттэй холбоотой байна.
- ✓ **Ойн нөөц ашигласны төлбөр** 727.8 сая төгрөгөөр давж биелсэн нь Булган, Цэнхэр, Жаргалант сумтай ААН-үүд гэрээ хийж хуш модны самрыг үйлдвэр, аж ахуйн зориулалтаар ашиглан борлуулж ажилласантай холбоотой байна.
- ✓ **Торгуулийн орлого** 541.2 сая төгрөгөөр давж биелсэн нь татварын цахим систем, цахим банкны үйлчилгээг ашиглан жолооч нар торгуулийг хурдан шуурхай төлөх боломжтой болж, орлого төвлөрсөнтэй холбоотой.
- ✓ **Нэр заагдаагүй бусад орлого** 556.9 сая төгрөгөөр давж биелсэн нь Цэнхэр, Жаргалант сумд тус орлогыг өндөр дүнгээр давуулан биелүүлсэн нь нөлөөлсөн байна.

Татварын 6 нэр төрлийн, татварын бус 2 нийт 8 нэр төрлийн орлого 1.4 - 1,877.9 сая төгрөгөөр буюу нийт **2,634.8** сая төгрөгөөр тасарчээ. Үүнд: Зарим өндөр дүнгээр тасарсан татварын болон татварын бус орлогыг тодруулбал:

- **Хүүгийн орлого** 1,877.9 сая төгрөгөөр тасарсан. Энэхүү орлогыг Сангийн Яамнаас Засгийн газрын дамжуулан зээлийн гэрээний эргэн төлөлт, хүүгийн орлого нийт 2,495.8 сая төгрөгөөр тодотгон хянасан байна. Гүйцэтгэлээр аймгийн төсвийн урьд оны үлдэгдлээс 550.0 сая төгрөг, Ар ус Ундарга ОНӨХХК-с 68.0 сая төгрөг нийт 618.0 сая төгрөгийг төвлөрүүлж, өөрөөр төвлөрөх эх үүсвэргүйгээс тасарсан байна.
- **Малын тоо толгойн албан татварын орлого** 365.7 сая төгрөгөөр тасарсан нь 2023 оны хаваржилт, өвөлжилт хүндэрч мал ихээр хорогдсоноос татвар хураалтад хүндрэл үүссэн, сумдын татварын хэмжээ харилцан адилгүй өөр тогтоогдсон зэрэг нь нөлөөлжээ.
- **Хадгаламжийн хүүгийн орлого** 165.6 сая төгрөгөөр тасарсан нь хадгаламжийн хүү буурснаас иргэд хадгаламжаас мөнгөө татсантай холбоотой байна.
- **Газрын төлбөр** 115.2 сая төгрөгөөр тасарсан нь Цэнхэр суманд уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг БМНС" ХХК нь газрын төлбөрөө төлөөгүйтэй холбоотой байна.
- **Ус рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого** 96.9 сая төгрөгөөр тасарсан нь тус орлогын төлөвлөлттэй холбоотой байна.
- **Ногдол ашгийн орлого** 9.6 сая төгрөгөөр тасарсан нь орон нутгийн өмчит Ар ус Ундарга ХХК, Архангайд үйлдвэрлэв ОНӨААТҮГ нь ашиггүй ажилласантай холбоотой.
- **Газрын дуудлага худалдааны орлого** 2.3 сая төгрөгөөр тасарсан нь Хотонт, Төвшрүүлэх, Эрдэнэбулган сум дуудлага худалдааг бүрэн зохион байгуулаагүйтэй холбоотой байна.
- **Хог хаягдлын хураамж** 1.4 сая төгрөгөөр тасарсан нь Булган, Өндөр-Улаан, Ихтамир, Хашаат сумдын орлогын дутуу төвлөрүүлэлттэй холбоотой байна.

### Аудитын илрүүлэлт № 1



*Орон нутгийн төсвийн орлогод төлөвлөгдсөн хог хаягдлын хураамж, газрын дуудлага худалдааны орлогууд бүрэн төвлөрөх боломжтой байсан байна. Харин Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлтийг төсвийн тодотголоор 100.0 сая төгрөгөөр нэмэгдүүлснээс шалтгаалан гүйцэтгэлээр тасарсан байх тул орлогын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж, төлөвлөгөөг үндэслэлгүйгээр төлөвлөхгүй байхад анхаарч ажиллах зөвлөмжийг*

*Сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлт:*

Сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар орон нутгийн орлогыг нэр төрлөөр жигд ханган биелүүлээгүй нийт 135.4 сая төгрөгийн зөрчил илэрч 53.9 сая төгрөгт 1 албан шаардлага, 81.5 сая төгрөгийн 9 зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна.



- ✓ **Аймаг, сумдын төрийн сангийн төлбөр тооцоонд тавих дотоод хяналт хангалтгүйгээс төсөв хооронд гүйлгэн зарцуулсан зөрчил өмнөх оноос 24.0 хувиар өссөн байна.**



Сангийн Сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсөл боловсруулах журам”-ын 4.3.2<sup>1</sup>-т заасан хугацаанд орон нутгийн төсөвт байгууллагуудын 2023 оны төсвийн төслийг холбогдох маягтын дагуу хүлээн авч хянан Сангийн Яамнаас ирүүлсэн удирдамж чиглэлийн дагуу нэмэлт тооцооллуудыг хийж, төсвийн урсгал зардлыг төсөв захирагч бүрээр төлөвлөсөн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамжид заасны дагуу Архангай аймгийн орон нутгийн 2023 оны төсвийн суурь зарлагын төслийг 39,733.7 сая төгрөгөөр боловсруулж, Төсвийн тухай хуулийн 8.4.3 дахь заалтын дагуу Сангийн яаманд хүргүүлснийг Сангийн яам 7,404.7 сая төгрөгөөр буюу 18.6 хувиар бууруулан 32,329.0 сая төгрөгөөр хянасан байна.

Хүргүүлсэн санал ба анхны болон тодотгон батлагдсан суурь зарлагын судалгаа

сая төгрөгөөр

Код	Зардлын ангилал	2023 он санал	Анх батлагдсан	Тодотгон батлагдсан	Зөрүү /анх болон тодотгосон/
24	ОРОН НУТГИЙН ЗАСАГ ЗАХИРГАА	39,733.7	32,329.0	37,685.4	5,356.4
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	39,733.7	32,329.0	37,685.4	5,356.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	38,053.9	30,674.9	36,031.3	5,356.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,679.8	1,654.1	1,654.1	0.0

2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн “Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулиар төрийн албан хаагчдын үндсэн цалинг нэмэгдүүлэх, мөн дамжуулан зээлийн хүүгийн төлөлттэй холбоотойгоор орон нутгийн суурь зарлагыг анх баталсан дүнгээс **5,356.4** сая төгрөгөөр нэмэгдүүлж, **37,685.4** сая төгрөгөөр Сангийн яамнаас хянажээ.



Аймгийн ТЕЗ-ийн 2023 оны төсвийн гүйцэтгэлд орон нутгийн төсвийн шууд захирагчийн 47, тусгай сан-41(ОНХС, ХХС, халамжийн сан, мал хамгаалах сан), Тогтмол зардал (Боловсролын -68, Эрүүл мэндийн -18, соёлын-22, спортын-1), аймгийн засаг дарга дансны зардлын гүйцэтгэл, нийт 198 байгууллагын тайлан нэгтгэгдсэн.

Нийт 64,892.5 сая төгрөгийн зарлагын 40,743.2 сая төгрөг буюу 62.8 хувийг орон нутгийн төсвөөс, 10,740.4 сая төгрөг буюу 16.5 хувийг ОНХС-аас, 9,730.1 сая төгрөг буюу 15.0 хувийг урьд оны үлдэгдлээс, 3,678.8 сая төгрөг буюу 5.7 хувийг төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр хуваарилсан байна.

Аймгийн төсвийн 2023 оны нийт зарлага фискал /fiscal/ программд /төсвийн гүйцэтгэлийн тайлангаар/ нийт 64,892.5 сая төгрөг төлөвлөгдөж, гүйцэтгэлээр 55,072.7 сая төгрөгийг зарцуулан, төсвийн гүйцэтгэл 84.9 хувьтай тайлагнагджээ.

Аймгийн ТЕЗ-ийн 2023 оны төсвийн зарлагын 59.9 хувийг урсгал зардалд, 31.3 хувийг хөрөнгийн зардалд 8.8 хувийг эргэж төлөгдөх зээлд төлөвлөж, зарцуулсан байна

<sup>1</sup> сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн төсөвт байгууллага болон тусгай зориулалтын гэрээний үндсэн дээр санхүүжих улсын төсвийн байгууллагын суурь төсвийн саналыг нэгтгэн аймаг, нийслэлийн Засаг даргад жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор хүргүүлнэ



Архангай аймгийн ТЕЗ-ийн 2023 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан



Орон нутгийн 2023 оны төсвийн зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгаа

сая төгрөгөөр

ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл		2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл				Тайлант оны төлөвлөгөө өмнөх оны төлөвлөгөөнөөс	Тайлант оны гүйцэтгэл өмнөх оны гүйцэтгэлээс
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	51,675.3	42,228.6	64,892.5	55,072.7	9,819.8	84.9	13,217.2	12,844.1
А. Урсгал зардал	32,027.8	29,120.8	38,880.8	36,458.4	2,422.4	93.8	6,853.0	7,337.6
Б. Хөрөнгийн зардал	15,619.7	10,522.7	20,283.7	16,202.7	4,081.0	79.9	4,664.0	5,680.0
В. Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	4,027.8	2,585.1	5,728.0	2,411.6	3,316.4	42.1	1,700.2	(173.5)

Хүснэгтээс харахад тайлант оны төсвийн гүйцэтгэлийн төлөвлөгөө өмнөх оны төлөвлөгөөнөөс 13,217.2 сая төгрөгөөр, гүйцэтгэл 12,844.1 сая төгрөгөөр буюу 23.3 хувиар есжээ.

Энэ нь тайлант онд төрийн албан хаагчдын үндсэн цалинг Засгийн газраас нэмэгдүүлж, ОНХС-ийн санхүүжилт өмнөх оноос өссөн зэрэгтэй холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар нийт төлөвлөгөө, гүйцэтгэлийн зөрүү 9,819.8 сая төгрөгөөр тайлагнагдсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- ✚ Аймаг, сумын удирдлагын байгууллагуудын урсгал зардлаас хэмнэж төвлөрүүлсэн нийт 2,422.4 сая төгрөг,
- ✚ Сумдын ОНХС-д малын тоо толгойн албан татвараар орох орлого бүрэн төвлөрөөгүй, мөн бусад шалтгаанаар 4,081.0 сая төгрөгийн төлөвлөгдсөн арга хэмжээ тайлант хугацаандаа хэрэгжээгүй,
- ✚ Сумын хоршоо хөгжүүлэх сангийн зээл болон ЗГ-ын дамжуулан эргэн зээлийн төлөлтөөс шалтгаалан 3,316.4 сая төгрөг байна.

**Архангай аймаг байгуулагдсаны 100 жилийн ойн хүрээнд зарцуулагдсан зардлын гүйцэтгэл:**

Аймгийн ИТХ-ын 2023 оны 03 дугаар сарын 09-ны өдрийн “Аймгийн 2022 оны шилжих үлдэгдлийг хуваарилан, аймгийн 2023 оны төсөвт зохицуулалт хийх тухай” 05 дугаар тогтоолоор аймаг байгуулагдсаны 100 жилийн ой тохиохтой холбогдуулан төсвийн урьд оны үлдэгдлээс 360.0 сая төгрөг, Сангийн Яамнаас хянасан тайлант оны зардлаас 340.0 сая төгрөг, нийт 700.0 сая төгрөг баталжээ. Үүнийг аймгийн ЗДТГ-ын улсын баяр наадам гэсэн хөтөлбөрт төлөвлөн, 699.8 сая төгрөгийг зарцуулжээ.

**Илрүүлэлт №2**

Архангай аймаг байгуулагдсаны 100 жилийн ойн хүрээнд иргэд, байгууллагаас өгсөн хандив тусламжийг “Хангайн наадам” төрийн бус байгууллага хүлээн авч, ойн арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд ойн хүрээнд бий болсон хандивтай холбоотой хөрөнгийг бүртгэж тайлагнаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4-т “Төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх”, 25.7-д “Тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана”, 25.8-д “Төсвийн ерөнхийлөн захирагч тусламж, хандив авсан тухай баримтын хувийг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн санд нэг сарын дотор хүргүүлнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.



Аймаг байгуулагдсаны 100 жилийн ойн хүрээнд хүлээн авсан хандивын хөрөнгийг холбогдох байгууллагын данс бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлээ.

*Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлт:*

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн зарцуулалт, дотоод хяналттай холбоотой **275.1** сая төгрөгийн зөрчилд 39 албан шаардлага, **21.1** сая төгрөгийн зөрчилд 15 төлбөрийн акт тогтоосон байна. Зөрчлийг ангилан авч үзвэл:

- Сангийн сайдын 2021 оны 10 дугаар 29-ны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг зөрчиж, төсөвт зохицуулалт хийлгүйгээр төсвийг зориулалт бус зарцуулсан **270.6** сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.
- Орон нутгийн төсвийн шууд захирагч 15 байгууллага цалин хөлс, илүү цаг, үр дүнгийн урамшуулал, хоол унааны хөнгөлөлтийг илүү, дутуу тооцож давхардуулан олгосонтой холбоотой **25.5** сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

### **Аудитын илрүүлэлт №3**



Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн зарцуулалттай холбоотой илэрсэн зөрчилд үндэслэн аудитаас Төсвийн Ерөнхийлөн захирагч, аймгийн СТСХ-ийн зүгээс аймгийн бүх шатны төсөв захирагчдын төсөв санхүүгийн сахилга батыг сайжруулах, төсвийн зарцуулалттай холбоотой нэгдсэн арга зүйгээр ханган ажиллах, дотоод хяналтыг хэрэгжүүлэх, зөрчил дутагдлыг давтан гаргахгүй байх арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг хүргүүлээ.

- ✓ **Аймгийн ТЕЗ-ийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн чанарын болон тоон хэмжээний үзүүлэлтийг оновчтой тодорхойлж төлөвлөөгүйгээс гүйцэтгэлийн үнэлгээг тооцож үнэлэх боломжгүй байна.**

Аймгийн ИТХ-ын 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн "Аймгийн 2023 оны тодотгосон төсөв батлах тухай" 17 дугаар тогтоолоор "Аймгийн ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг ТЕЗ, түүний хэрэгжүүлэх 11 салбар чиглэлийн дагуу баталжээ.

### **Аудитын илрүүлэлт №4**

Дээрх "Аймгийн ТЕЗ-ийн 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг хянаж үзэхэд үр дүнгийн чанарын болон тоо хэмжээний шалгуур үзүүлэлт, суурь түвшин, 2023 оны зорилтот түвшнийг оновчтой тодорхойлоогүй хэт ерөнхий байдлаар батлуулсан нь Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2-т "Хөтөлбөрийн зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг тодорхойлсон байх" гэсэн заалт, Сангийн Сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан Төсвийн төсөл боловсруулах журамтай бүрэн нийцэхгүй байна.



Засаг даргаас зөв оновчтой тодорхойлж ирүүлсэн ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн чанарын болон тоо хэмжээний шалгуур үзүүлэлтийг батлах зөвлөмжийг аймгийн ИТХ-д хүргүүлээ.



Төсвийн тухай хулийн 54 дүгээр зүйлийн 54.5.1, 54.5.3, 54.5.4, 54.5.5-д заасны дагуу аймгийн ТЕЗ-ийн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг ирүүлж, харин ТЕЗ-ийн хүрэх үр дүн, түүний танилцуулгыг ирүүлээгүй бөгөөд аудитын явцад судалгаагаар гаргуулж авлаа. Цаашид ТЕЗ-ийн хүрэх үр дүн, түүний танилцуулгыг төсвийн гүйцэтгэлийн иж бүрдлийг хангуулан аудитад ирүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

- ✓ **Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд орон нутгийн төсөвт 2,649.1 сая төгрөгийн хэмнэлт бий болж, зөрчил өмнөх оноос зөрчил 82.2 хувиар буурсан байна.**



Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийн дагуу ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад 7 байгууллагатай холбоотой **22.1** сая төгрөгийн дараах зөрчил илэрч, **12.2** сая төгрөгийн зөрчилд зөрчлийг таслан зогсоох 3 албан шаардлага, **9.9** сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоосон байна.

Өмнөх онд орон нутгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэй холбоотой 124.5 сая төгрөгийн зөрчил илэрч байсан бол тайланд онд 22.1 сая төгрөгийн зөрчил илэрч, өмнөх оноос зөрчил буурсан байна.

*Тайлант онд 134 төсөвт байгууллага урсгал болон хөрөнгийн зардлаас нийт 2,649.1 сая төгрөгийг хэмнэлтийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.*

## АУДИТЫН ДҮГНЭЛТ

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитаар нийт 100.6 сая төгрөгийн зөрчил илэрсэнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулан ажиллах, дотоод хяналтыг сайжруулах талаар 4 заалт бүхий зөвлөмжийг аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүллээ.

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Аймгийн Засаг даргаас тайлагнасан орон нутгийн 2023 оны нэгдсэн төсвийн нийт орлого 55,322.4 сая төгрөг, нийт зарлага 55,072.7 сая төгрөгийн гүйцэтгэлийг баталгаажууллаа.
2. Орон нутгийн төсвийн орлогыг 8 нэр төрлөөр 2,634.8 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсний 71.3 хувь буюу 1,877.9 сая төгрөг нь засгийн газрын дамжуулан зээлийн хүүгийн орлого байна.
3. Аймаг, сумдын төрийн сангийн төлбөр тооцооны дотоод хяналт хангалтгүйгээс төсөвт зохицуулалт хийхгүйгээр төсөв хооронд гүйлгэн зарцуулсан зөрчил 270.6 сая төгрөг болж өмнөх оноос 24%-аар өссөн байна.
4. Аймаг байгуулагдсаны 100 жилийн ойн хүрээнд бий болсон хандив тусламжийн орлогыг бүртгэж тайлагнаагүй байна.
5. Аймгийн ТЕЗ-ийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн чанарын болон тоон хэмжээний үзүүлэлтийг оновчтой тодорхойлж төлөвлөөгүйгээс гүйцэтгэлийн үнэлгээг тооцож үнэлэх боломжгүй байна.
6. Аймгийн хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийж биелэлтийг 90.9%, аймгийн ИТХ-аас “Хангалттай” гэж үнэлсэн байна.



7. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд орон нутгийн төсөвт 2,649.1 сая төгрөгийн хэмнэлт бий болж, зөрчил өмнөх оноос 82.2 хувиар буурсан байна.
8. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 78.1 хувьтай байна.

### АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн холбогдох албан тушаалтнуудад дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

#### Аймгийн ИТХ-ын дарга Б. Батжаргал танаа

- ✓ Засаг даргаас зөв оновчтой тодорхойлон ирүүлсэн аймгийн ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн чанарын болон тоо хэмжээний шалгуур үзүүлэлтийг хянаж, батлах

#### Аймгийн Засаг дарга Б.Цэрэннадмид танаа

- ✓ Хог хаягдлын хураамж, газрын дуудлага худалдааны орлого, ус рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө тасарсан шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийж орлогын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулан төлөвлөгөөг нэр төрөл тус бүрээр биелүүлэх арга хэмжээ авах
- ✓ Бүх шатны төсөв захирагчдын төсөв санхүүгийн сахилга батыг сайжруулах, төсвийн зарцуулалттай холбоотой нэгдсэн арга зүйгээр ханган ажиллах, төрийн сангийн дотоод хяналтын үр нөлөөг сайжруулж, зөрчил дутагдлыг давтан гаргахгүй байх арга хэмжээ авч ажиллах
- ✓ Аймаг байгуулагдсаны 100 жилийн ойн хүрээнд хүлээн авсан хандивын хөрөнгийг холбогдох байгууллагын данс бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулах